



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/400

Мандагзовь

Г Газар ашиглуулах тухай 7

Монгол Улсын Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь, 27 дугаар зүйлийн 27.1.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Баянжаргалан сумын ИТХТэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 1/15 дугаар албан тоот, аймгийн Засаг даргын 2010 оны 454 дүгээр захирамжийн дагуу Баянжаргалан сумын нутаг дэвсгэр "Мануулт" гэдэг нэртэй газарт ашигт малтмалын МҮ-1455А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1.107 56 31.6, 45 29 41.55 2. 107 56 1.58, 45 29 41.56 3.107 57 56.1.49, 45 30 1.61 4. 107 56 31.5, 45 30 1.6 солбицол бүхий 40 га газрыг уул уурхайн олборлолтын зориулалтаар "Үнэн анд" ХХК-д /2885565/ гэрээний үндсэн дээр ашиглуулсугай.

Хоёр. Дээрх аж ахуйн нэгжтэй газар ашиглах гэрээ байгуулах, газраа зориулалтын дагуу ашиглаж байгаа болон газрын төлбөрийн төлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж)-д, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Баянжаргалан сумын Засаг дарга (Г.Туяа)-д, аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Газар ашиглах гэрээ болон газар хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөг биелүүлж, газрын төлбөрөө гэрээний дагуу төлж байхыг газар ашиглагч аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



438010284